



Монгол улсын сангийн яам  
Монгол Улсын 2011 оны төсвийн төсөл

# МОНГОЛ УЛСЫН 2011 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

*/ЗГ-аас УИХ-д өргөн барьсан/*

Сангийн яамны ТБГ-ын дарга Б.Батжаргал



## Агуулга

### I. Ерөнхий мэдээлэл

### II. Монгол улсын 2011 оны төсвийн төсөл

- ОУВС-тай тохирсон “Stand by” хөтөлбөрийн нөхцөл, тохирсон шалгуур үзүүлэлтүүд
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн талаар
- Төсвийн орлогод баримталж буй зарчим, нэмэгдүүлэх боломж
- Урсгал зардалд баримталж буй зарчим, хийгдсэн өөрчлөлтүүд
- Хөрөнгө оруулалтанд баримталж буй зарчим , хийгдсэн өөрчлөлтүүд
- Монгол улсын төсвийн төслийн үр дүнгийн үзүүлэлтүүд

### III. Дүгнэлт



## Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын “Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг зөвшөөрөх тухай” 2010 оны 40 дүгээр тогтоол батлагдаж Монгол Улсын 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2011 оны төсвийн нийт зарлагыг ДНБ-ий 40.4 хувь (3,250.0 орчим тэрбум төгрөг), нийт алдагдлыг ДНБ-ий 5.0 хувь байхаар баталсан.

**Олон Улсын Валютын Сан-тай хамтран хэрэгжүүлж буй “Стэнд-бай” хөтөлбөрийн дагуу Засгийн газар дунд хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангах, 2011 оны төсвийн зарлагыг 3,250.0 тэрбум төгрөгөөс хэтрүүлэхгүй байх** чиглэл баримталж, энэ хүрээнд 2011 оны ТХМ-ийн үзүүлэлтүүдийг УИХ баталсан.

Монгол Улсын 2011 оны төсвийн төслийг УИХ-ын 40 дүгээр тогтоол Төсвийн хүрээний мэдэгдэл, Засгийн газрын 194 дугаар тогтоолоор батлагдсан зарлагын хязгаарт нийцүүлэн төсвийн зарлагыг **3,250.0** тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байхаар боловсрууллаа.



**ОУВС-тай тохирсон “Stand by” хөтөлбөрийн нөхцөл,  
төхирсон шалгуур үзүүлэлтүүд**

Энэхүү хөтөлбөр 2010 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болох бөгөөд хэрэв 11 сар хүртэл Монгол Улсын Засгийн газар хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд улсын төсөвт Дэлхийн банк (**30 сая ам.дол**), Азийн хөгжлийн Банк (**20 сая ам.дол**), Японы Засгийн газар (**20 сая ам.дол**)-аас орж ирэх нийт **70 сая ам.долларын** хөнгөлөлттэй зээлийг хүлээн авах нөхцөл биелэгдэх болно.

Хөтөлбөрүүд	Хүлээгдэж буй санхүүжилт / сая ам.доллар /	Шалгуур үзүүлэлт	Хүлээн авах байгууллага
Дэлхийн банкны "Хөгжлийн бодлогын зээл"-ийн 2 дахь үе шат	30.0	Үндсэн нөхцлүүд биелэгдсэн. 2010 оны 10 сарын сүүлчээр захирлуудын хурлаар шийднэ.	Улсын төсөв
АХБ-наас хэрэгжүүлж буй "Нийгмийн халамжийн хөтөлбөр" 2 дахь үе шат	20.0	Нийгмийн халамжийн багц хуулийг 2010 оны УИХ-ын намрын чуулганаар батлуулсан байх	Улсын төсөв
Японы Засгийн газраас хэрэгжүүлж буй "Нийгмийн халамжийн хөтөлбөр" 2 дахь үе шат	20.0	Нийгмийн халамжийн багц хуулийг 2010 оны УИХ-ын намрын чуулганаар батлуулсан байх	Улсын төсөв
<b>НИЙТ</b>	<b>70.0</b>		



# Монгол улсын сангийн яам

## Монгол Улсын 2011 оны төсвийн төсөл

Хугацаа	Одоо хэрэгжиж байгаа хууль		
<b>2002 оноос мөрдөгдөж байна.</b>		<b>Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль</b>  -Төсвийн орлого, зарлагын ангилал -Төсвийн гүйцэтгэлийг тайлагнах -Төсвийн нягтлан бодох бүртгэлтэй холбогдсон харилцааг тус тус зохицуулж байна.	<b>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль</b>  -Төсөв зохиох -Батлах -Санхүүжүүлэх -Гүйцэтгэлийг хангахтай холбогдсон асуудлыг зохицуулж байна.
<b>Хуулийг өргөн барих хугацаа</b>	<b>Шинээр баталж хэрэгжүүлсэн хууль</b>	<b>Шинэчлэн найруулж сайжруулах хууль</b>	
<b>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төслийг өнөөдөр буюу 2010 оны 1 сарын 12-нд өргөн барьж, 6 сарын 24-нд батлагдсан.</b>  <b>Нэгдсэн төсвийн тухай хуулийн төслийг 2010 оны 7сард өргөн барьсан</b>	<b>Монгол улсын төсвийн тогтвортой байдлын тухай хууль</b>  - Төсвийн бодлого, стратегийг тодорхойлоход төсвийн удирдлагын зарчим ба төсвийн тусгай шаардлагыг тогтоож, дунд, урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг хангах тогтолцоог бий болгоход чиглэсэн.	<b>Нэгдсэн төсвийн тухай хууль</b>  Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль, төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийг нэгтгэн нэгдсэн нэг хуультай болох гэж байна.  /Бүх шатны байгууллагуудаас санал авч байна/	

2011 оны санхүүгийн жилээс дээрх хуулиуд хэрэгжиж эхэлнэ.

## ТӨСВИЙН ТОГТВОРГҮЙ БАЙДЛЫН УЛМААС ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН СӨРӨГ ҮР ДАГАВАР, СУРГАМЖ

- Сүүлийн жилүүдийн уул уурхайн орлогын өсөлтийг дагасан төсвийн зарлагын тэлэлт, дэлхийн санхүүгийн хямрал, импортлогдсон үнийн өсөлт инфляцийг хөөрөгдөж **33%**-д хүргэсэн сургамж бий.
- Зэсийн үнэ буурахад төсвийн орлого дагаж огцом буурсан хэдий ч төсвийн зарлага буураагүй тул Засгийн газар **400 орчим сая ам.доллар**ын гадаад зээл авсан.
- Зэсийн үнийн бууралт болон гадаад худалдааны тэнцлийн алдагдал огцом нэмэгдсэн, улмаар дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр төгрөгийн ханш (**1\$~1730₮**) суларч эхэлсэн.
- Төгрөгийн ханшийг тогтворжуулахаар дотоод зах зээлд гадаад цэвэр нөөцийн 50 орчим хувийг гаргасанаар Монгол Улсын гадаад цэвэр нөөц **500 гаруй сая ам доллараар** огцом буурсан.
- Төсвийн болон экспортын орлогод голлох нөлөө үзүүлэгч зэс, алтны үнэ өссөн үеийн төсвийн зарлагын тэлэлтээр дамжуулан эдийн засагт нийлүүлсэн 600 тэрбум төгрөгийн хагас нь хөрөнгө оруулалтын чиглэлээр зарцуулагдан барилгын салбарын эрэлтийг нэмэгдүүлсэн бол нөгөө хагас нь өрх гэрт бэлэн мөнгөөр олгосноор хөөсөн эрэлтийг бий болгосон.
- Макро эдийн засаг, төсвийн тогтворгүй байдал нь Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг бууруулахад голлох шалтгаан болсон. **Moody's - B1Stable → B1Negative; S&P – BB- Stable → BB- Negative**
- Монгол улс Азийн орнуудаас санхүүгийн хямралд хамгийн гүнзгий өртсөн орны ангилалд орох болсон (**Дэлхийн Банкны тайланд орон хариуцсан тэргүүлэх 1/3 Рожерийн хийсэн албан ёсны дүгнэлтээс**)

Эдийн засгийн бодлогыг хүчтэй болгоход макро эдийн засгийн тогтворжуулалтыг хангахуйц бүтцийн ба эрх зүйн орчны шинэ загварчлал чухал



Мөчлөгийн өөрчлөлт дагасан бус мөнгөний бодлого


Мөчлөгийн өөрчлөлт дагасан бус төсвийн бодлого

Валютын уян хатан ханш

Санхүүгийн зөв тогтолцоо

Гадаад хүчин зүйлээс авах цочролыг багасгах нь мөчлөгийн өөрчлөлт дагасан бус бодлогыг хэрхэн хэрэгжүүлэхээс хамаарна.


# ЧИЛИ улсын Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төлөвлөгөөт ба бодит ашгийн байдал



**7400  
U\$S/t  
on**


**2200  
U\$S/t  
on**

# ТӨСВИЙН ТЭНЦЭЛ 2003-2009 ОНУУДАД




# ИНФЛЯЦИ, БОДИТ ХҮҮГИЙН ТҮВШИНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ БОЛОН ТӨГРӨГ, ГАДААД ВАЛЮТЫН УРСГАЛЫН ХӨДӨЛГӨӨН

Инфляци, бодит хүүгийн т үвшин



Төгрөг гадаад валют ын урсгал





## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 оны 6 дугаар сарын 24-нд батлагдан гарсан билээ. Хуулийн дагуу төсвийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон орлогоор хуримтлал үүсгэх зорилгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцож, төсвийн тусгай шаардлагуудыг баримтлан 2011 оны төсвийн төслийг боловсрууллаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу зэс, нүүрсийг гол нэр төрлийн эрдэс баялагт хамааруулж 2011 оны төсөвт эдгээрийн үнийг хуулийн дагуу тооцож, төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцлоо.

# ХУУЛИЙН ГОЛ АГУУЛГА НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА ТОГТООЖ БАРИМТЛАХ

Төсвийн макро түвшний тогтворжилтыг хангах 4 төрлийн тусгай шаардлага байна. *(олон улсын жишгийг харгалзан тодорхойлсон)* Үүнд:

Хуулийн 6.1.Төсөвт дараахь тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна:

6.1.1.нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

6.1.2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

6.1.3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;

6.1.4.уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх.


Төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг жил бүр тодотгож тооцно.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 4 жилд нэг удаа өөрчлөх.

## ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫН ТУХАЙ

- “төсвийн тусгай шаардлага” гэж нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн, төсвийн богино, дунд, урт хугацааны бодлого, төсвийн хүрээг тодорхойлоход баримтлах энэ хуулиар тогтоосон зохистой үзүүлэлтийн түвшин, харьцаа, хязгаарлалтыг хэлнэ.
- “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын 3 хувь, эсхүл түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялагийг хэлнэ.
- **Гол нэр төрлийн эрдэс баялаг** гэдэгт 2010 оны байдлаар зэс (16.90%), алт (3.03%) орж байна. Улмаар томоохон ордуудын ашиглалтаас хамаараад гол нэр төрлийн эрдэс баялаг дээр мөнгө, төмөр, уран нэмэгдэх боломжтой юм.

**Гол нэр төрлийн эрдэс баялгийн орлого төсөвт эзлэх хувиар**





## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

- 2011 онд дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн үнэ дунджаар 8425.0 ам.долларт хүрэх тооцоог олон улсын санхүүгийн байгууллагууд гаргаж байна. Гэхдээ 2011 оны төсөвт зэс, нүүрсний үнийг дэлхийн зах зээл дээрх үнээр бус Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу зэсийн үнийг 5983.1 ам.доллар, боловсруулсан нүүрсний үнэ 98.8 ам.долларт байхаар төсвийн орлогыг тооцсон. Ингэж тооцоход 2011 онд зэс, нүүрснээс төсөвт 583.7 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна.
- Төсөвт тусгасан дээрх зэс, нүүрсний үнээс 2011 онд дэлхийн зах зээл дээрх үнэ өндөр байх тохиолдолд үүсэх үнийн зөрүүгээс авах татварын орлого нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагад нийцсэн, нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлагдах юм.

# Гол нэр төрлийн тэнцвэржүүлсэн орлого

- Тэнцвэржүүлсэн үнийн томъёолол:
  - Өнгөрсөн үеийн тоо мэдээлэл болон ирээдүйн төсөөллийг ашигладаг → Урт хугацааны трендийг харуулна.
- Урт хугацааны тэнцвэржүүлсэн үнийн тооцоонд олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц дараах тоон мэдээллийг ашиглана:
  - IMF Commodity Prices database (history)
  - Bloomberg and other (projections)


# Зарлагын тусгай шаардлага

- Зарлагын шаардлага нь дараах нөхцөл байдлуудыг шийдвэрлэх үүрэгтэй:
  - Төсвийн зардлыг тогтвортой, тогтмол өсгөх
  - Шилжилтийн үе шатанд тохиолдох зарлагын гэнэтийн тэлэлтээс сэргийлэх
  - Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөнд түлхүү анхаарах

- Төсвийн зарлагын тусгай шаардлага:


Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх

# Expenditure rule



**Шаардлага:** Зарлагын өсөлтийн хувь нь  $\text{Max}$  (Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь; эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн тренд) хэтрэхгүй байхаар хуульчилсан.

# Төсвийн зарлагын тусгай шаардлага



# Төсвийн тэнцлийн тусгай шаардлага

- Төсвийн алдагдал нь шилжилтийн заалттай:
  - 2011 онд тусгай шаардлага үйлчлэхгүй.
  - 2012 онд тусгай шаардлага үйлчлэхгүй.
  - 2013 оноос хойш төсөв ашигтай эсвэл төсвийн алдагдал ДНБ-ий 2%-аас хэтрэхгүй.

# Өрийн тусгай шаардлага


- Тогтвортой өрийн түвшинг баримтлах
- Өрийн түвшин шилжилтийн заалттай.
  - 50% in 2011
  - 60% in 2012
  - 50% in 2013
  - 40% later on

# Өрийн тусгай шаардлага

- Бусад улсуудын хувьд өрийн өндөр түвшинтэй байдаг нь:
  - Валютын өндөр нөөцтэй
  - Эрсдэлийг хүлээх чадвартай
  - Засгийн газрын санхүүгийн хөрөнгийн хуримтлал өндөр байдагтай холбоотой.

# Засгийн газрын өрийн түвшин

Government Gross and Net Debt  
(% of GDP)



# Өрийн хязгаарлалт: Грекийн жишээ

- Өр болон төсвийн алдагдал. Грекийн хувьд засгийн газрын өрийн түвшин нь ДНБ-ий 100 хувьд хүрсэн бөгөөд мөн төсвийн алдагдал нь ДНБ-ий 12 хувьд хүрч өссөн.
- Төсвийн алдагдлыг худлаа тайлагнаж мэдээлж байсан нь олон нийтэд ил болсноос болж Грекийн ЗГ-т итгэх итгэл ОУ-ын түвшинд буурсан.

## ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА БАРИМТЛАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

---

**Хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн тусгай шаардлагыг дараах үйл ажиллагаанд баримтална:**

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн тэнцлийн зорилтыг тодорхойлж тусгах;
- дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах
- Төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, батлах, хяналт тавих;
- Төсвийн төсөл боловсруулах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.

# Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тохиолдол

---

Хуулийн 8.1.Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг дараахь тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно:

- 8.1.1.тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад “0”, эсхүл түүнээс бага, хасах хувьтай бол;
- 8.1.2.гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувь ба түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол.

## Төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах

---

- **Хуулийн 15.1:**
- Улсын Их Хурал нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсөвт, эсхүл Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эдгээр баримт бичгийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэ хөтөлбөр нэмж тусгах тохиолдолд уг асуудал нь макро эдийн засгийн төлөв байдалд болон төсвийн тусгай шаардлагыг баримтлахад хэрхэн нөлөөлөх талаар Засгийн газраар үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж болно.


## ТӨСӨВ ТОГТВОРЖУУЛАХ ГОЛ ХЭРЭГСЭЛ

---


### Гол хэрэгсэл нь: Төсвийн огтворжуулалтын сан

- Төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагад нийцсэн нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Төсвийн тогтворжуулалтын сантай байна.
- Тус санд тэнцвэржүүлсэн орлогоос давсан бүх орлогыг оруулна.
- Санг ямагт мөнгө хэлбэрээр хадгалж удирдана.
- Сан байгуулах минимум хэмжээ ( $\leq$ ДНБ-ний 5%)
- Сангийн эх үүсвэр бүрдүүлэлт, (төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлого, төсвийн ашиг, бусад)
- Сангийн хязгаарлагдмал зориулалт (зөвхөн төсөв тогтворжуулахад)
- Сангийн удирдлага, хяналт, тайлагнал (Энэ талаар Төв банк-Засгийн газрын эрх, үүрэг, хариуцлага, сангийн өгөөжийн норм, эрсдлийн менежементийн зэрэг харилцааг зохицуулах гэрээ байгуулж мөрдөнө)

**ЭРДЭС БАЯЛАГЫН ҮНЭ ТӨЛӨВЛӨЖ БАЙСНААС ДАВЖ ӨССӨН ҮЕД  
ТОГВОРЖУУЛАЛТЫН САНД ХӨРӨНГӨ ХУРИМТЛАГДАХ БӨГӨӨД ҮНЭ  
БУУРСАН ҮЕД УГ САНГААС ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙХ**




Төсөвлөгдсөн  
Эрдэс баялгийн  
орлого



Гүйцэтгэлээр  
гарсан эрдэс  
баялгийн орлого




Төсөвлөгдсөн  
Эрдэс баялгийн  
орлого



Гүйцэтгэлээр  
гарсан эрдэс  
баялгийн орлого



# ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН ЗАГВАР



- Энэхүү загварыг ихэнхи улс орнуудын тогтворжуулалтын сандаа ашигласан байна.
  - Тринидад Тобаго болон Чили улсын тогтворжуулалтын сангууд
  - Норвегийн Тэтгэвэрийн сангууд дээрх загвартай байдаг байна.



## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Төсвийн тогтворжуулалтын сан нь төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгынхоо хүрээнд доод тал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээнд хүртэл хуримтлуулах ба ДНБ-ий 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө бүрдэх хүртэл ашиглахгүй хуримтлал хэлбэрээр хадгалагдах хуультай. Санд ДНБ-ий 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө хуримтлагдах хүртэл зөвхөн төсвийн орлогын тасалдал үүсэх нөхцөлд тогтворжуулалтын сангаас орлогыг нөхөх зориулалтаар зарцуулалт хийгдэх юм. Төсвийн тогтворжуулалтын сан ДНБ-ийн 10 хувиас давсан хэмжээний хуримтлалтай болсон тохиолдолд сангийн хөрөнгийн ДНБ-ий 10 хувиас давсан санхүүгийн хуримтлалын хөрөнгөөр дотоод болон гадаад зах зээлд санхүүгийн хөрөнгө оруулалт хийж эхлэх юм.




## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

- Төсвийн тогтворжуулалтын сангаас дотоод, гадаад зах зээлд хийх хөрөнгө оруулалтын оновчтой хэмжээг инфляцийн түвшинг нэг оронтой тоонд хязгаарлах, төгрөгийн ханшийн огцом хэлбэлзлээс сэргийлэх, макро эдийн засгийн болон төсвийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй байх зорилготой уялдуулан Монгол банкны ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр жил бүр тогтоож байхаар хуульд заасан.
- Гадаад зах зээлд хийх хөрөнгө оруулалтыг Монгол банкаар гүйцэтгүүлэх бөгөөд дотоод зах зээлд хийх хөрөнгө оруулалтыг зөвхөн төрийн өмчит хөгжлийн банкны буцаан худалдан авах нөхцөлтэй гаргасан урт хугацаат үнэт цаасыг худалдан авах замаар хийх юм. Тогтворжуулалтын сангаас эдийн засгийн потенциал чадавхийг нэмэгдүүлэх, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг дэмжих, эдийн засгийн суурийг бэхжүүлэх, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх зорилготой хөгжлийн дотоод хөрөнгө оруулалтуудыг Төрийн өмчит хөгжлийн банкаар дамжуулан дунд, урт хугацааны зээлээр санхүүжүүлэх юм. Хөгжлийн энэхүү хөрөнгө оруулалт нь зөвхөн төмөр замын сүлжээ, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчим хүчний цахилгаан станц байгуулах, олон улсын болон Европын холбооны стандартын шаардлага хангасан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх төсөл арга хэмжээ байх юм.



### ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын санд 2011 онд ойролцоогоор 164.6 орчим тэрбум төгрөгийн орлого төвлөрөх төлөвтэй байна. Улмаар 2013 оноос Төсвийн тогтворжуулалтын сангаас хөгжлийн хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.



## ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД ХЭРЭГЛЭХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

---

18.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлийг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- 18.2.Засгийн газраас өргөн мэдүүлсэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн нэгдсэн төсвийн төсөл нь төсвийн тусгай шаардлагыг хангаагүй тохиолдолд төсвийн төслийг буцаана.
- 18.3.Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төсвийн тусгай шаардлагыг энэ хуулийн 8.1-д зааснаас бусад шалтгаанаар хангаагүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4-т заасны дагуу Засгийн газрыг огцруулах тухай санал гаргах үндэслэл болно.
- 18.4.Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсөв батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн тусгай шаардлагыг хангаагүй нь Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндэслэл болно.

# ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ: ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ЗОРИУЛАЛТ

---

## Төсвийн тогтворжуулалтын сангийн зориулалт:

Тус сангийн хөрөнгөөс дор дурдсан санхүүжилт хийх зориулалтаар улсын төсөвт шилжүүлж болно:

- тухайн жилийн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө, төсвийн орлогын гүйцэтгэлийн зөрүүг;
- төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зүйлд заасны дагуу төсвийн тусгай шаардлага баримтлахгүй байх тохиолдол үүссэн нөхцөлд шаардагдах төсвийн санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрийг тус тус санхүүжүүлэхээр.

## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ШИЛЖИЛТИЙН ХУГАЦААНЫ ТАЛААР

Тусгай шаардлагууд / Төсвийн жил	2011 он	2012 он	2013 он
Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох	<b>Баримтлана</b>	<b>Баримтлана</b>	<b>Баримтлана</b>
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх	Баримтлахгүй	Баримтлахгүй	<b>Баримтлана</b>
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх	Баримтлахгүй	Баримтлахгүй	<b>Баримтлана</b>
Улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх	<b>Баримтлана</b>  /хуулиар <b>50</b> хувь байж болох бөгөөд 40 хувиас илүү гарсан 10 хувиар зөвхөн Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах зориулалттай/	<b>Баримтлана</b>  /хуулиар <b>60</b> хувь байж болох бөгөөд 40 хувиас илүү гарсан 20 хувиар зөвхөн Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах зориулалттай/	<b>Баримтлана</b>  /хуулиар <b>50</b> хувь байж болох бөгөөд 40 хувиас илүү гарсан 20 хувиар зөвхөн Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах зориулалттай/

2002 онд явагдсан төсвийн хууль эрх зүйн орчинг сайжруулах, шинэчлэх, хамрах хүрээг нь өргөтгөх зайлшгүй шаардлага тулгарснаар хийгдэх төсвийн хоёр дахь үе шатны шинэчлэлийн хүрээнд төсвийн тогтвортой байдлын тогтолцоог хуульчилан тогтоосноор:

- Төсвийн бодлогоор дамжуулж Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах,
- Бизнесийн тогтвортой таатай орчин бүрдэж, Монгол Улсын зээлжих зэрэглэл нэмэгдэх
- Гадна, дотны хөрөнгө оруулагчдын сонирхолыг нэмэгдүүлэх, итгэлийг бэхжүүлэх баталгаа бүрдэх
- Үндэсний мөнгөн хуримтлалын тогтолцоог бүрдүүлнэ.



## 2011 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН ТУХАЙ

- Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг ТХМ-ээс 282.8 тэрбум төгрөгөөр, 2010 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 323.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн **3056.9 тэрбум төгрөгт** хүргэхээр тооцлоо.
- УИХ-аар шинээр батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон орлогоор хуримтлал үүсгэх зорилгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцож ирэх 2011 оны төсвийн төсөлд тусгалаа.
- Ирэх онд дэлхийн зах зээл дэх алтны үнийг **1250.0** ам доллар байхаар тооцож төсвийн төсөлд тусгалаа. Дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг 2011 онд дунджаар **8425.0** ам.долларт хүрэхээр тооцлоо.



## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГЫГ ТООЦОХ

- Төсвийн тогтвортой байдлын хуулийн 4.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг “гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого”-д “ЗЭС” болон “НҮҮРС”-нээс төвлөрөх орлого хамаарч байна. Алтны хувьд дээрх шаардлагыг хангаж чадахгүй байгаа тул 2011 оны хувьд хамаарахгүй болно.
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу 2011 онд зэс, нүүрсний үнийг ОУВС-ын сүүлийн 12 жилийн дундаж, “Bloomberg” агентлагийн 2010-2013 оны зэс, нүүрсний үнийн төсөөллийн дунджаар тооцоход зэсийн үнэ **5983.1 ам.доллар**, боловсруулсан нүүрсний үнэ **98.8 ам.долларт** байхаар байна. Зэс, нүүрснээс төсөвт **583.8 тэрбум төгрөг** төвлөрөхөөр байна.
- Зэс, нүүрсний үнийн төсөөллийг ирэх 2011 онд одоогийн байгаа түвшинд хэлбэлзэнэ гэж үзвэл Тогтворжуулалтын санд ирэх онд ойролцоогоор 164.6 орчим тэрбум төгрөгийн орлого төвлөрөх төлөвтэй байна.



## Төсвийн орлогод хийгдсэн бодлогын өөрчлөлтүүд

- УИХ-аар шинээр батлагдсан Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу агаарын бохирдлын төлбөрөөр **30.0** тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөгдсөн.
- “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай” хууль 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх тул ирэх 2011 онд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар төсөвт орлого төвлөрөхгүй байхаар тооцож байна.
- “Оюу толгой” ордын бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан “Оюу толгой” ХХК-аас ирэх 2011 онд улсын төсөвт **163.2** тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэхээр тооцож тусгалаа.
- Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангах, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг орон нутагт нь олгох зорилгоор орон нутгийн ИТХ-аас дараах хоёр төрлийн татварын хувь хэмжээг УИХ-аас баталсан хязгаарт багтаан тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамааруулан тогтоож байхаар хуулийн төслүүдийг боловсруулсан. Үүнд:
  - Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль /8.0 тэрбум төгрөгийн орлого орон нутгийн төсөвт нэмж төвлөрөх боломжтой болох юм./
  - Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль /2.0-7.0 тэрбум төгрөгийн орлого орон нутгийн төсөвт нэмж төвлөрөх боломжтой болох юм./



## Төсвийн орлогод хийгдсэн бодлогын өөрчлөлтүүд

- УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу алтны олборлолт, тушаалтад хяналт тавих зорилгоор олборлосон алтыг зөвхөн Монголбанкинд худалдаж байхаар Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсрууллаа. Үүний үр дүнд төсвийн орлого **5.6** тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр төсвийн төсөлд тусгасан.
- Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль 1993 оны 7 дугаар сарын 15-нд УИХ-аар батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд улсын тэмдэгттэй холбоотой зарим зохицуулалтыг бусад хуулиар зохицуулж байсныг улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэгтгэх, хураамжийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан шинэчлэн тогтоох зайлшгүй шаардлага бий болсон тул Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан төсвийн орлогыг **19.8** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тусгасан.
- Импортоор орж ирж буй суудлын автомашины насжилтийн бүтцийг сайжруулах зорилгоор үйлдвэрлэгдсэнээс хойш 0-3 жил болж буй суудлын автомашины онцгой албан татварыг нэмэгдүүлэхгүйгээр, одоогийн хуульд үйлдвэрлэгдсэнээс хойш 4 жил болсон автомашин 9 жил болсон автомашин адил хэмжээний татвар төлж байгааг өөрчлөн 4-6 жил, 7-9 жил болгож, мөн хөдөлгүүрийн багтаамжийг 2500 ба түүнээс дээш гэснийг “2501-3500”, “3500 дээш” болгож өөрчилж 4-өөс дээш жилийн насжилттай суудлын автомашины онцгой албан татварыг 2 дахин нэмэгдүүлэхээр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа. Төсвийн орлогыг **10.5** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тусгасан.



## Төсвийн орлогод хийгдсэн бодлогын өөрчлөлтүүд

- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлээд байна. Хуулийн төслийг боловсруулахдаа уул уурхай, газрын тосны үйлдвэрлэл хөгжсөн бусад орны туршлага, тэдний ашигт малтмалын үнийн өсөлтөд ногдуулдаг татварын төрлийг судалж үзсэн болно.
- Зэсийн үнийн төсөөллийг гаргадаг олон улсын байгууллагууд 1 тн цэвэр зэсийн үнийг 2011 онд 8425 ам.доллар, 2012 онд 8810 ам.доллар, 2013 онд 9500 ам.долларт хүрч, зэсийн эрэлт өсөн, цаашид үнэ тогтвортой өндөр байх хандлагатай байгаа талаар мэдээлээд байгаа тул Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг нэмэгдүүлэн дээд хувь хэмжээг 15 хувь болгох замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.
- Ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн өсөлтөд өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулснаар **202.5** тэрбум төгрөгийн нэмэлт орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцож 2011 оны төсвийн төсөлд тусгасан.



## 2011 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА

❖ Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн нийт зарлага 3,251.6 тэрбум төгрөгт төлөвлөгдсөнөөр 2010 оны төлөвлөгөөнөөс 143.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Улсын төсвийн зарлага 2010 оны дүнгээс 382.9 тэрбум төгрөгөөр буурч төлөвлөгдсөн бол, Хүний хөгжил сангийн зарлага 470.3 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн зарлага 85.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр тооцлоо.

	2010 оны төсөв .1.	2011 оны төсвийн төсөл .2.	2010 оноос өссөн дүн /2-1/	2010 онтой харьцуулахад
<b>НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,339.6</b>	<b>2,984.7</b>	<b>645.1</b>	<b>27.6%</b>
Цалин хөлс	646.0	790.2	144.2	22.3%
Бараа үйлчилгээний бусад зардал	517.7	469.1	-48.6	-9.4%
Зээлийн үйлчилгээний төлбөр	54.9	45.6	-9.3	-17.0%
Татаас ба шилжүүлэг	1,120.9	1,679.6	558.7	49.8%



# Монгол улсын сангийн яам

## Монгол Улсын 2011 оны төсвийн төсөл

### Урсгал зардалд баримталж буй зарчим, хийгдсэн өөрчлөлтүүд

<b>2010 оны урсгал зардал /нэгдсэн төсөв/</b>	<b>2,339.60</b>
+ 2010 онд цалин, тэтгэврийг 30%-иар нэмэгдүүлснээр	225.0
+ Эрчим хүчний үнийн өсөлтөөр	14.1
+ 2010 оны тодотголоор шийдвэрлэсэн арга хэмжээний зардлыг бүтэн жилээр тооцох	15.5
- 2010 онд хэрэгжүүлсэн нэг удаагийн арга хэмжээ	-31.1
<b>= 2011 оны суурь зарлага</b>	<b>2,563.1</b>
+ ХХС-аас иргэн бүрт 21 мянган төгрөг сар бүр олгох	378.5
+ ХХС-аас оюутны сургалтын төлбөрт 500,000 төгрөг олгох	82.5
+ Алдарт эхийн одон олгох нөхцлийг өөрчилснөөр	15.8
+ Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100 жил, Ардын хувьсгалын 90 жил, Хүннү гүрний 2200 жилийн ой, тэгш ой тохиосон 14 аймгийн ой, анхны 5 яамны ойн арга хэмжээ	2.5
+ Шинээр байгуулсан байгууллага, бүтэц, ХО-р ашиглалтад орсон объектын урсгал зардал, хууль эрхзүйн орчны өөрчлөлтийн улмаас нэмэгдсэн /цэвэр/	75.6
+ ЭМД төлөөгүй иргэдийн даатгалын нөхөн төлбөр	9.3
+ Гадаадын төсөл арга хэмжээний урсгал зардлыг төсөвт тусгах	23.9
- Бууруулсан урсгал зардлын дүн	-166.5
<b>=2011 оны төсвийн төслийн урсгал зарлага</b>	<b>2,984.7</b>



## 2011 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эхлүүлэн хэрэгжүүлэхээр тооцон 2011 онд улсын төсвийн хөрөнгөөр 76.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөлөө.
- Орон нутгийн хөгжлийг дэмжих, төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд хүн ам, газар нутгийн хэмжээ, ДНБ-н болон орон нутгийн татварын орлогын төвлөрүүлэлт зэргийг харгалзан 2011 онд аймаг тус бүрт дундажаар 560.0 сая төгрөг, нийслэлд 20 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтанд зарцуулах эрхтэйгээр олгохоор төсвийн төсөлд тусгалаа.



## ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ

Хүний хөгжил сангаас 2011 онд нийт **805.2 тэрбум төгрөгийн** хөрөнгийг санхүүжүүлэн дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

- Монгол Улсын иргэн бүрт сар бүр 21.0 мянган төгрөг олгоно.
- Төрөөс хариуцах ЭМДШ, хураамжийг санхүүжүүлнэ.
- Оюутны сургалтын төлбөрт нийт 165,000 оюутанд 500,000 төгрөг нийт 82.5 тэрбум төгрөг олгохоор тооцон хөрөнгийг тусгалаа.



# Монгол улсын сангийн яам

## Монгол Улсын 2011 оны төсвийн төсөл

### 2011 оны нэгдсэн төсвийн төсөл

Тэрбум төгрөг

Үзүүлэлт	2010 оны төсөв	2011 оны төсвийн төсөл	Өсөх / буурах
<b>Нийт орлого</b>	<b>2,645.7</b>	<b>3,056.9</b>	<b>411.2</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>3,107.9</b>	<b>3,251.6</b>	<b>143.7</b>
Урсгал зарлага	2,339.6	2,984.7	645.1
Хөрөнгийн зардал	607.8	162.3	-445.5
Үүнээс: Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалт	570.1	76.0	-494.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	160.4	104.5	-58.9
<b>ТЭНЦЭЛ</b>	<b>(462.2)</b>	<b>(194.7)</b>	<b>267.5</b>
Алдагдлын ДНБ-д эзлэх хувь	<b>-6.4%</b>	<b>-2.5%</b>	
<b>ДНБ /тэрбум төгрөг /</b>	<b>7,171.4</b>	<b>7,836.4</b>	<b>665.0</b>

# Өөрчлөлтүүд

- Бодитоор батлагдах төсөв
  - Зарлага 4,070.3 тэрбум төг (ДНБ-ий )
  - Дутагдах эх үүсвэр – нийт 622.9 тэрбум төг
    - Улсын төсөв 270.3 тэрбум төг
    - Хүний хөгжил сан 352.7 тэрбум төг
  - Эх үүсвэрийн дутагдлыг Гарын үсгийн баталгааны орлогоор нөхөх
- Зарлагын өсөлт нь эдийн засагт оруулах бэлэн мөнгөний урсгалаас шалтгаалж байна. Үүнд:
  - Цалин, тэтгэврийн сангийн 30% өсөлт
  - Хүний хөгжил сангийн зарлага



## Дүгнэлт

- 2011 оны төсвийн төслийг боловсруулахад 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2011 оны зарлагын хязгаар, ОУВС-тай тохирсон Станд-Бай хөтөлбөрийн шаардлагуудыг чиглэл болгон эдгээрийг хангах зарчмаар боловсрууллаа.
- Дээрх зарчимуудыг баримтлан Монгол улсын 2011 оны төсвийн төслийг боловсруулахад нэгдсэн төсвийн нийт орлого **3,056.9 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **39.0 хувь**, нэгдсэн төсвийн нийт зарлага **3,251.6 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **41.5 хувь**, нэгдсэн төсвийн нийт алдагдал **194.7 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **-2.5 хувь** болохоор байна.
- Үүнээс, Улсын төсвийг авч үзвэл 2011 оны Улсын төсвийн нийт орлого 2,303.0 тэрбум төгрөг, нийт зарлага 2,040.2 тэрбум төгрөг, улсын төсвийн нийт тэнцэл 262.8 тэрбум төгрөгийн ашигтай гарахаар байна.
- Харин Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн нийт орлого 320.5 тэрбум төгрөг, нийт зарлага 805.2 тэрбум төгрөг буюу 2010 оны зарлагаас 470.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд **Хүний хөгжил сангийн нийт алдагдал 484.7 тэрбум төгрөгт** хүрэхээр байна.



## Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсөв

Сангийн нэр	2011.01.01-ний үлдэгдэл	Орлого	Зарлага	2011.12.31-ний үлдэгдэл	
Нийгмийн даатгалын сан	194,481.9	632,387.5	604,025.2	222,844.2	
Үүнээс:	Тэтгэврийн даатгалын сан	35,633.7	449,928.5	455,192.2	30,370.0
	Тэтгэмжийн даатгалын сан	9,253.0	18,896.6	30,836.9	-2,687.3
	ҮОМШӨ-ний даатгалын сан	23,929.1	30,930.0	20,940.6	33,918.5
	Ажилгүйдлийн даатгалын сан	46,336.4	19,573.6	8,745.5	57,164.5
	Эрүүл мэндийн даатгалын сан	79,329.7	113,058.8	88,310.0	104,078.5



## Нийгмийн даатгалын сангийн өглөгийн барагдуулалт

ҮЗҮҮЛЭЛТ		ДҮН (сая т өг)
1. 2007/12/31-ний байдлаар т өсвөөс т өлөх өглөг		236,000.0
2. 2008-2010 онд т өлсөн нийт		59,153.4
Үүнээс:	А. 2008 оны төсвийн гүйцэтгэлээр илүү санхүүжүүлсэн	26,103.7
	Б. 2009 оны төсвийн гүйцэтгэлээр илүү санхүүжүүлсэн	15,510.3
	В. 2010 оны төсвийн тодотголд өр барагдуулахаар тусгасан	17,539.4
3. Төлбөл зохих үлдэгдэл		176,846.6
2011 оны т өсвийн т өсөлд өглөг т өлөх зориулалт аар т усгасан дүн		20,000.0
ҮЛДЭХ		156,846.6